

НИЙГМИЙН ДААТГАЛ, ХУРИМТЛАЛЫН САНГИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт от түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл -ийн хувь
НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ АРГА, ХЭМЖЭЭ							
Стратегийн зорилт 2.4.5. Нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хүн амын насны бүтцийн хэтийн төлөвийг харгалзсан нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг эрчимжүүлэх хүрээнд:							
1.1	Зорилт 1.1: Олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлнэ.	үйл ажиллагааны зардал	УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /тоо/	0	1	-	-
1.1.1	Арга хэмжээ 1.1.1 Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлнэ. /Алсын хараа-2050 3.1.4, ТТШТББ /2015-2030/ 3.2.17, МУХТЖҮЧ 2021-2025 3.1.1, МУЗГҮАХ 2024-2028 2.1.3.5/	үйл ажиллагааны зардал	УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /тоо/	0	1	Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ГБХНХ-ын сайдын 2024 оны А/48 дугаар тушаалаар байгуулан ажиллаж, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг болон хуулийг дагаж өргөн мэдүүлэх 13 хуулийн төслийг тус тус боловсруулсан. Хувийн нэмэлт тэтгэврийн даатгалын тухай олон улсын туршлага, одоо зах зээл ижил төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн талаарх судалгааг боловсруулсан. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын	90

						<p>төслийг хамтран батлахаар 2025.02.05-ны өдрийн 01/374 дүгээр албан бичгээр, 2025.02.25-ны өдрийн 01/637 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлж, үзэл баримтлалыг хамтран баталсан. Хуулийн төсөлд яамны газар, хэлтэс, ажлын хэсгийн гишүүн байгууллагуудаас ирүүлсэн саналыг тусгаж ажилласан. Мөн хуулийн төслийн явцын танилцуулгыг 2025.04.14-ний өдөр Төрийн нарийн бичгийн даргад танилцуулж, өргөтгөсөн ажлын хэсгийн хурлыг 2025.04.17-ны өдөр хийж хуулийн төслийг эцэслэн хэлэлцэж дууслаа. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн болон дагалдах хуулийн төсөлд Засгийн газрын гишүүд, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкнаас санал авахаар 2025.05.05-ны өдрийн 01/1446 дугаар албан бичгээр тус тус хүргүүлж, ирүүлсэн саналыг тусгасан. Засгийн газрын 2025.06.04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, УИХ-д өргөн мэдүүлэхийг дэмжлээ. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>
			Дагах хуулийн төсөл /тоо/	0	12	13
			Боловсруулсан үзэл баримтлал /тоо/	0	1	1

			Хавсаргасан тооцоо, судалгаа /тоо/	0	2	2	
1.2	Зорилт 1.2: Нийгмийн даатгалын сангийн тогтвортой байдлыг хангасан нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэл хийнэ.	үйл ажиллагааны зардал	УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /тоо/	0	1	-	-
1.2.1	<p>Арга хэмжээ 1.2.1 Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлнэ.</p> <p>/МУЗГҮАХ 2024-2028 3.2.1.5./</p>	үйл ажиллагааны зардал	УИХ-д өргөн барьсан хуулийн төсөл /тоо/	0	1	<p>Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, Үзэл баримтлалыг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 01/1778 дугаар албан бичгээр Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлснээр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хамтран баталсан. Хуулийн төслийг боловсруулах хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн зарим зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, Хуулийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайланг тус тус боловсруулсан. Хуулийн төслийг ЗГХЭГ-т 01/1841 дугаар албан бичгээр хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний хурлаар хэлэлцэн дэмжиж УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон.</p> <p>2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд</p>	90

						<p>нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулсан бөгөөд Үзэл баримтлалыг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 01/1783 дугаар албан бичгээр Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлснээр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хамтран баталсан. Хуулийн төслийг боловсруулах хүрээнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, Хуулийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайланг тус тус боловсруулсан. Хуулийн төслийг ЗГХЭГ-т 01/1841 дугаар албан бичгээр хүргүүлсэн бөгөөд ын газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний хурлаар хэлэлцэн дэмжиж УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон.</p>	
			Боловсруулсан үзэл баримтлал /тоо/	0	1	2	
			Дагах хуулийн төсөл /тоо/	0	3	3	
			Хавсаргасан тооцоо, судалгаа /тоо/	0	2	6	
1.2.2	Арга хэмжээ 1.2.2 Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах	үйл ажиллагааны зардал	Боловсруулсан судалгаа /тоо/	0	1	Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “өмчийн бүх	100

	<p>гэрээгээр тохирсон хөдөлмөрийн хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахдаа уян хатан, хөнгөлөлттэй байх нөхцөлийг бүрдүүлэх талаар холбогдох тооцоо, судалгаа хийнэ. /МУЗГҮАХ 2024-2028 3.2.1.6/</p>					<p>хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан хэд хэдэн ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа бол зөвхөн эхний гэрээгээр тохирсон цалин хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл төлөх” болон “хөдөлмөрийн гэрээний дагуу албан журмаар даатгуулагч өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа бол нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй” гэсэн уян хатан зохицуулалтыг холбогдох тооцоо, судалгаанд үндэслэн тусгасан болно.</p>	
1.2.3	<p>Арга хэмжээ 1.2.3 Монгол Улсаас гадаад улстай нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээр байгуулах чиглэлээр хамтран ажиллах, хэлэлцээ хийнэ. /МУЗГҮАХ 2024-2028 2.3.1.6/</p>	<p>үйл ажиллагааны зардал</p>	<p>Нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах чиглэлээр хамтран ажилласан улс /тоо/</p>	2	3	<p>Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийн төслийг Засгийн газрын 2025.05.07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, УИХ-ын холбогдох байнгын хороотой зөвшилцөхөөр тогтсон. Энэ шийдвэрийн дагуу УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2025.05.23-ны өдрийн хуралдаанаар Хэлэлцээрийн төслийг хэлэлцэн дэмжиж, ЗГ-т гарын үсэг зурах эрх олгосон бөгөөд Хэлэлцээрт Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Бүгд Найрамдах Австри Улсын Европ, олон улсын харилцааны яамны Ерөнхий нарийн бичгийн дарга Николаус Маршик нар</p>	100

					<p>2025.05.26-ны өдөр гарын үсэг зурсан.</p> <ul style="list-style-type: none"> • Австралийн Холбооны Улстай байгуулах нийгмийн хамгааллын хэлэлцээрийн төслийг боловсруулах шинжээчдийн ажлыг хэсгийн II шатны хэлэлцээг 2025.03.25-ны өдөр цахим хэлбэрээр хийсэн бөгөөд Монголын талаас хэлэлцээрийн төсөлд санал тусгах, дараагийн шатны хэлэлцээг 2025 оны 9 дүгээр сард Монгол Улсад биечлэн хийхээр урьдчилсан тохиролцоонд хүрч, хамтран ажиллаж байна. • Оросын Холбооны Улстай байгуулах нийгмийн хамгааллын хэлэлцээрийн төслийг боловсруулах шинжээчдийн ажлыг хэсгийн V шатны хэлэлцээг 2025.05.29-ний өдөр цахим хэлбэрээр хийж, хамтран ажиллаж байна. Хэлэлцээгээр Оросын талаас хэлэлцээрийн төсөлд санал тусгах, Удирдлагын тохиролцооны төслийг боловсруулах, Монголын талаас Монгол Улсад ажиллаж НДШ төлж байгаа орос иргэдийн мэдээллийг оросын талд хүргүүлэх, Засгийн газрын бүтцийн өөрчлөлттэй холбоотой яамдаас дахин санал авах зэрэг асуудлыг хэлэлцэн тохиролцож хамтран ажиллаж байна. 		
1.2.4	<p>Арга хэмжээ 1.2.4 Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар</p>	<p>үйл ажиллагааны зардал</p>	<p>Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн эсэх</p>	0	1	<p>Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн</p>	100

	хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлнэ. /МУЗГҮАХ 2024-2028 2.3.1.6/		/Тийм:1 / Үгүй:0/			төслийг боловсруулж, Засгийн газрын 2025.03.19-ны хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд Засгийн газраас Хуулийн төслийг дэмжиж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон. Энэ шийдвэрийн дагуу Засгийн газраас Хуулийн төслийг 2025.05.09-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. Хуулийн төслийг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хурлаар хэлэлцэн дэмжиж, УИХ-ын 2025.05.23-ны өдрийн чуулганаар хэлэлцүүлсэн боловч дэмжигдээгүй болно.	
ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Стратегийн зорилт 2.4.5. Нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хүн амын насны бүтцийн хэтийн төлөвийг харгалзсан нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг эрчимжүүлэх хүрээнд							
2.1.	Зорилт 2.1: Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг эрчимжүүлнэ.		Хэрэгжүүлсэн арга хэмжээ /тоо/	0	3		
2.1.1	Арга хэмжээ 2.1.1 Үндэсний баялгийн сангаар дамжуулж иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд хүүгийн орлого болон ногдол ашгийг бүртгэнэ. /МУЗГҮАХ 2024-2028 2.1.3.1/	Байгалийн баялаг, ногдол ашиг	Хуримтлуулсан хөрөнгийн хэмжээ, /төгрөг/	495.6 тэрбум	507.1 тэрбум	<ul style="list-style-type: none"> Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журмыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын нийт 3,565.9 мянган иргэний хуримтлалын нэрийн дансанд 138.9 мянган төгрөгийн бүртгэл үүсгэж, И-Монгол системийн Профайл цэсийн "Чингис Хаан" Үндэсний Баялгийн сан хэсгээс иргэн өөрийн нэрийн дансны үлдэгдлийг харах нөхцөлийг бүрдүүлсэн. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалт, Засгийн газрын 2024.05.01-ний өдрийн 179 дүгээр тогтоолын дагуу Хуримтлалын санд 2024 онд 	100

					<p>төвлөрүүлсэн эх үүсвэрийг орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг санхүүжүүлж, хуульд заасны дагуу арвижуулах зорилгоор 2024.05.09-ний өдрийн 81-0524/171 дүгээртэй “Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах гэрээ”-г Сангийн яам болон Монголбанк хооронд нэг жилийн хугацаатай байгуулсан.</p> <ul style="list-style-type: none">• Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах 2024 оны гэрээний хугацаа 2025.05.09-ний өдөр дуусгавар болсонтой холбогдуулан тус гэрээний дагуу тооцогдсон хүүгийн өгөөжийг Монголбанк дахь Төрийн сангийн Хуримтлалын сангийн дансанд төвлөрүүлж, тус яам Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.3-т заасан хүүг иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд хуваарилан бүртгэл хөтлөх шаардлагатай байгаа талаар 2025.06.06-ны өдрийн 01/1906 тоот албан бичгийг Сангийн яам болон Монголбанканд хүргүүлсэн.• Монгол Улсын Засгийн газраас Хуримтлалын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байгаа бөгөөд Засгийн газрын 2025.02.19-ний өдрийн 9, 2025.02.26-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэлийн дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн энгийн хувьцааны 2024 оны 2, 3 дахь удаагийн ногдол ашгаа хуримтлалын нэрийн дансандаа хуримтлуулах эсэх талаар “И-Монголиа” цахим системээр	
--	--	--	--	--	---	--

					<p>дамжуулан иргэдээс баталгаажуулах санал асуулгыг явуулахад 600 иргэн ногдол ашгаа хуримтлуулах санал өгсөн болно.</p> <ul style="list-style-type: none">• "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн энгийн хувьцааны 2024 оны 2, 3 дахь удаагийн ногдол ашгийг Хуримтлалын сангийн хуримтлалын нэрийн дансандаа хуримтлуулах саналыг "И-Монголиа" цахим системээр дамжуулан гаргасан иргэдийн ногдол ашгийг Монголбанкн дах Төрийн сангийн Үндэсний баялгийн сан (Хуримтлалын сан) шилжүүлэх зохицуулалтыг тусгасан "Хуримтлалын сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан 2025.03.21-ний өдрийн 01/874 тоот албан бичгээр яамдаас санал авч, Засгийн газрын, 2025.04.09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 177 дугаар тогтоолоор батлуулсан.• Иргэн өөрийн хүсэлтээр хуримтлалын нэрийн дансанд оруулсан 2024 оны "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 1072 ширхэг хувьцааны ногдол ашгийн орлогыг төрийн үйлчилгээний нэгдсэн И-Монголиа системийн Профайл цэсийн "Чингис Хаан" Үндэсний Баялгийн сан хэсгээс Хуримтлалын нэрийн дансны мэдээллээс шалгах боломж бүрдүүлэхээр ажиллаж байна.• Цаашид Үндэсний баялгийн сангийн бодлогыг иргэдийн хүсэл сонирхолд нийцүүлж, иргэн өөрийн
--	--	--	--	--	--

						<p>хүсэлтээр хуримтлалын нэрийн дансандаа нэмэлт орлого хуримтлуулах боломж бүрдүүлэх зорилгоор “И-Монголиа” төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс 23-ны өдөр хүртэлх хугацаанд “Үндэсний баялгийн сангийн хуримтлалын нэрийн дансандаа нэмэлт орлого хуримтлуулах хүсэлтэй эсэх талаар” иргэдээс санал асуулга авч ажилласан.</p> <p>• Энэхүү санал асуулгад нийт 273.2 мянган иргэн хамрагдсан нь 18-аас дээш насны Монгол Улсын нийт иргэдийн 12.5 хувийг эзэлж байна. Санал асуулгад оролцогчдын хамгийн их буюу 18.5 хувь нь хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хуримтлалын нэрийн дансандаа хуримтлуулахыг дэмжсэн бол хамгийн бага буюу 14.1 хувь нь НӨАТ-ын буцаан олголтыг хуримтлалын нэрийн дансандаа хуримтлуулахыг дэмжсэн байна.</p>	
2.1.2	<p>Арга хэмжээ 2.1.2. Хуримтлалын сангийн үйл ажиллагааг орон сууцжуулалттай уялдуулах зорилгоор 2025 оны мөнгөн хөрөнгийг орон сууцны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт хөрөнгө оруулах, холбогдох тооцоо судалгаа хийнэ.</p>	Хуримтлалын сангийн эх үүсвэр	Хуримтлалын сангийн эх үүсвэрээр орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэний тоо	2084 иргэн	2200	<p>• Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар Хуримтлалын санд уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ногдол ашгаас 507.1 тэрбум төгрөг, хүүгийн орлогоор 55.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр, Хуримтлалын сангийн хөрөнгийг санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулах хэмжээг 562.1</p>	100

					<p>тэрбум төгрөг байхаар тус тус хуульчилсан.</p> <ul style="list-style-type: none">• Энэхүү эх үүсвэрийг төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны санхүүжилтийн хөтөлбөрийг санхүүжүүлэх хэлбэрээр санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулж, арвижуулах, арга хэмжээ авч холбогдох гэрээ байгуулах эрх олгох агуулга бүхий Засгийн газрын 2025.05.07-ны өдрийн “Хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 228 дугаар тогтоолыг батлуулсан.• Засгийн газрын 2025.02.05-ны өдрийн “Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангийн хөрөнгийн удирдлагын бодлого батлах тухай” 72 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хуримтлалын сангийн хөрөнгийн удирдлагыг бодлого”-ын 3.1-т “Сангийн хөрөнгийн удирдлагыг Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.3-т заасны дагуу Монголбанк Засгийн газартай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу гэрээний төсөл, танилцуулга, хуралдааны тэмдэглэлийн төслийг боловсруулан Засгийн хуралдаанд танилцуулахаар 2025.05.20-ны өдрийн 01/1665 тоот албан бичгээр хүргүүлж, Засгийн газрын 2025.06.04-ний өдрийн хуралдаанд танилцуулсан.• Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын
--	--	--	--	--	---

						<p>яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, нөгөө талаас Монголбанк хооронд 2025.06.02-ний өдрийн 98,А/132,2025/195,0525/183 дугаартай "Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах ерөнхий гэрээ"-г байгуулсан.</p>	
			Боловсруулсан судалгаа /тоо/	1	1	<p>Мөн Монголбанкнаас "Орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар арилжааны банкуудад хүсэлт гаргасан 17.0 мянган иргэний мэдээлэл"-ийг (хүссэн зээлийн хэмжээ, худалдан авахаар хүсэж буй орон сууцны хэмжээ, сарын орлого зэрэг ангиллаар) ирүүлсэн бөгөөд мэдээллийг нэгтгэн Үндэсний баялгийн сан орон сууцжуулалтын үндэсний хороонд хүргүүлсэн.</p> <p>Монгол Улсын Засгийн газар, Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хорооны орон сууцны урт хугацааны бодлого тодорхойлох, ипотекийн зээлийн эх үүсвэр, хүртээмжийг нэмэгдүүлэх, урт хугацаанд хэрэгжүүлэх санхүүжилтийн загварыг тодорхойлох зорилтын хүрээнд орон сууцны бодлого тодорхойлогчид болон банк санхүүгийн байгууллагын төлөөлөл хамтран ажиллаж "Орон сууцны санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх арга хэмжээний санал" боловсруулах чиглэлээр ажиллаж байна. Ипотекийн зээлийн бүтээгдэхүүнд нэн тэргүүнд хамрагдах орон сууцгүй, 1 ба түүнээс дээш хүүхэдтэй, ажил эрхэлдэг, өрхийн сарын орлого нь 1-</p>	

						<p>2 сая төгрөг хүртэл, 40 ба түүнээс доош насны өрхийн тэргүүлэгчтэй зорилтот 17,292 өрхийн мэдээллийг боловсруулан үүнээс дахин төлөвлөлт, нийслэлийн төсөл, дэд төвийн бүсүүдэд амьдарч 4,092 өрхийн мэдээллийг гаргаж Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хороонд хүргүүлсэн. Зорилтот бүлгийг тодорхойлох судалгааны хүрээнд анх удаа орон сууц авч буй залуу болон олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй гэр бүлийг тус тус орлогын түвшин, байршлаар тодорхойлсон болно.</p> <p>Бүгд Найрамдах Казахстан Улсын орон сууцны хөнгөлөлттэй зээл болон хадгаламжийн талаар мэдээлэл, судалгаа боловсруулсан. Бүгд Найрамдах Казахстан Улс зорилтот бүлгийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -олон хүүхэдтэй гэр бүл -хөгжлийн бэрхшээлтэй иргэн -хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд есгөж буй гэр бүл -өнчин, эцэг эхийн хараа хяналтгүй үлдсэн хүүхдүүд -залуу гэр бүл -анх орон сууц авч байгаа иргэн -ажилтны орон сууцны хөнгөлөлттэй зээл -бага орлоготой өрх зэрэг болно. 	
2.1.3	<p>Арга хэмжээ 2.1.3. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар “Хуримтлалын</p>	-	<p>Тушаал Батлуулсан маягтын тоо</p>	-	1	<p>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025.02.25-ны өдрийн “Маягт батлах тухай” А/54 дүгээр тушаалаар Хуримтлалын нэрийн дансны мөнгөн хөрөнгийг өвлөх хүсэлтийн маягтыг</p>	100

	нэрийн дансны мөнгөн хөрөнгийг өвлөх хүсэлтийн маягт"-ыг боловсруулж, батлуулна.					батлуулсан. Мөн "Хуримтлалын нэрийн дансны мөнгөн хөрөнгийг гэр бүлийн гишүүнд шилжүүлэх хүсэлт", "Хуримтлалын сангаас дэмжлэг авах хүсэлт"-ийн маягтын загварыг тус тус боловсруулсан.	
2.1.4	Арга хэмжээ 2.1.4 Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ. /МУЗГҮАХ 2024-2028 2.1.1.22/	Улсын төсөв	Тэтгэврийн нэмэгдэл /хувь/	0	6	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасны дагуу бүх тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулж 6 хувиар нэмэгдүүллээ. Энэхүү арга хэмжээний хүрээнд нийт 505.6 мянган тэтгэвэр авагч хамрагдаж, 300.0 тэрбум төгрөг зарцуулсан.	100
2.1.5	Арга хэмжээ 2.1.5 Итгэлцүүрийг улсын дундаж цалин, хэрэглээний үнийн өөрчлөлттэй уялдуулан боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.	-	Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлсэн эсэх /Тийм:1 / Үгүй:0/	0	1	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-т заасны дагуу улсын дундаж цалин, хэрэглээний үнийн өсөлттэй уялдуулан жил бүрийн 8 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө батлуулахаар заасан. Иймд 3 дугаар улиралд батлуулахаар бэлтгэж байна.	-
2.1.6	Арга хэмжээ 2.1.6 Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох ажлыг санамсаргүй түүврийн аргад үндэслэн өөр бүсийн эмч шийдвэрлэх шинэ тогтолцооны судалгаа хийж, зураглал боловсруулна.	Үйл ажиллагааны зардал	Боловсруулсан баримт бичгийн тоо	0	2	Монгол Улсын Засгийн газраас иргэдийн нийгмийн хамгааллын асуудлыг онцгойлон анхаарч, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаагийн нэг нь даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлан тогтоох, хөдөлмөр зохицуулалт хийх ажил юм. Энэ хүрээнд хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход даатгуулагч, хүний эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай солилцох мэдээллийн жагсаалтыг шинээр	90

						<p>боловсруулахаар холбогдох яамдтай хамтран ажилласан. Үүний үр дүнд даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалт тогтоох, сунгах, цуцлах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл солих, хөгжлийн бэрхшээлтэй хүний байнгын асаргааг тодорхойлох, сэргээн засах, сувилал, эмнэлгийн хуудас олгох, хяналт хийхэд шаардлагатай мэдээллийг санамсаргүй түүврийн аргад үндэслэн бүс хооронд цахимаар солилцох, шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор “Мэдээлэл солилцох тухай” Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2025.05.30-ны өдрийн А125,А/212 дугаар хамтарсан тушаалыг батлуулсан. Эрүүл мэндийн яаманд хамтран ажиллах тухай 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 01/538 дугаар албан бичиг хүргүүлсэн. Энэхүү тушаалаар батлагдсан мэдээлэл, зураглалыг холбогдох Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс мэдээллийн хур системээр дамжуулан авч Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Мэдээлэл технологийн төв турших ажлыг хийж байна.</p>	
ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Стратегийн зорилт 2.4.2. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, яамны үйл ажиллагаанд хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж сурталчлах, сургалт зохион байгуулах хүрээнд							
3.1	Зорилт 3.1: Нийгмийн даатгалын сангийн засаглалыг сайжруулах	үйл ажиллагааны зардал	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	0	3	-	

3.1.1	<p>Арга хэмжээ. 3.1.1 Нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг 10 хувиар бууруулна.</p>	үйл ажиллагааны зардал	Нийт өр төлбөрт эзлэх төлөгдсөн шимтгэлийн өрийн хувь	0	10 хувь	<p>Нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг шуурхай барагдуулах хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 01/1822 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн засаг дарга нарт харьяа аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газартай хамтран ажиллах талаар чиглэл хүргүүлсэн. Мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн ерөнхийлөн захирагч болон аймгийн засаг даргын хооронд хөтөлбөрийн хэрэгжүүлэлт, санхүүжилтийн талаар байгуулах гэрээнд нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын өрийг барагдуулах талаар зорилт арга хэмжээг тусган ажиллаж байна. Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оныг “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил” болгон зарлан ажиллаж байна. Үүний үр дүнд 2025 оны эхний үлдэгдэл 520.1 тэрбум төгрөгийн шимтгэлийн авлагаас 6 дугаар сарын байдлаар 210.6 тэрбум төгрөгийн авлагыг 40.4 хувиар бууруулсан боловч шимтгэлийн өр 596,6 тэрбум төгрөгт хүрч урсгал авлага буюу шинээр үүссэн өр 287.1 тэрбум төгрөг байна.</p>	50
3.1.2	<p>Арга хэмжээ. 3.1.2 Салбарын хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх манлайлал, ил тод байдлыг</p>	үйл ажиллагааны зардал	2025 оны шударга байдлын үнэлгээний дундаж оноо	2023 оны шударга байдлын үнэлгээ	80-аас доошгүй оноо	<p>Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/174, А/175 дүгээр тушаалын дагуу нийгмийн даатгалын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Нийгмийн даатгалын салбарын чиглэлээр хууль тогтоомж, дүрэм,</p>	100

	төлөвшүүлэх, олон нийтийн итгэлийг хүлээсэн албыг бэхжүүлэх үүднээс авлигын эрсдэлийг бууруулах тусгайлсан төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.			74.8 оноо		журам, заавар болон статистик мэдээллийг ГБХНХЯ-ны www.mlsp.gov.mn хуудас болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын www.ndaatgal.mn цахим хуудаст тухай бүр байршуулж ажил олгогч, иргэд, олон нийтэд хүргэж байна. https://mlsp.gov.mn/content/detail/3137 • Түүнчлэн, тайлант хугацаанд нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шинэчлэх хүрээнд олон нийтээс санал авахаар “Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, “Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус яамны вэбсайтын “Хууль эрх зүй” хэсэгт байршуулан олон нийтээс санал авч хэлэлцүүлсэн. https://mlsp.gov.mn/content?c=5
ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ						
4.1	Зорилт 4.1: Нийгмийн даатгалын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	үйл ажиллагааны зардал	Сэтгэл ханамжийн үнэлгээ дээшилсэн хувь	0	10-аас доошгүй	

4.1.1	<p>Арга хэмжээ. 4.1.1 Нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагааны цахимжилтыг эрчимжүүлнэ. /Алсын хараа-2050 3.1.5, МУЗГҮАХ 2024-2028 2.1.3.2/</p>	үйл ажиллагааны зардал	Шинээр цахимжуулсан үйлчилгээ /тоо/	0	2	<p>Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалт тогтоох, сунгах, цуцлах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл солих, хөгжлийн бэрхшээлтэй хүний байнгын асаргааг тодорхойлох, сэргээн засах, сувилал, эмнэлгийн хуудас олгох, хяналт хийхэд шаардлагатай мэдээллийг санамсаргүй түүврийн аргад үндэслэн бүс хооронд цахимаар солилцох, шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх ажлыг Эрүүл мэндийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтран зохион байгуулж байна. Энэ хүрээнд “Мэдээлэл солилцох тухай” Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2025.05.30-ны өдрийн А125 А/212 дугаар хамтарсан тушаалыг батлуулсан. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд эрүүл мэнд байгууллага, нийгмийн даатгалын байгууллага хооронд цахимаар мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> Түүнчлэн нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоолгох хүсэлтийг цахимаар хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг 2025 оны II-IV улиралд хийхээр төлөвлөж байна. Нийгмийн даатгалын цахим үйлчилгээний чанарыг сайжруулах хүрээнд үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээг https://portal.ndaatgal.mn/ цахим хуудсаар зохион байгуулж байна.
			Үйлчлүүлэгч /ажил олгогч, даатгуулагч/-ийн сэтгэл ханамжийн үнэлгээ	0	1	

4.1.2	<p>Арга хэмжээ. 4.1.2 Хуримтлалын нэгдсэн сангийн мэдээллийн нэгдсэн санг шинээр нэвтрүүлэх ажлыг үе шаттай авч хэрэгжүүлнэ.</p>	үйл ажиллагааны зардал	Суурь судалгааны тоо	-	1	<p>Засгийн газрын 2024 оны “Журам батлах тухай” 224 дүгээр тогтоолоор Хуримтлалын сангийн үйл ажиллагаанд шаардлагатай программ хангамж хөгжүүлэлтийг Санхүүгийн мэдээллийн технологийн төв Улсын төсөвт үйлдвэрийн газар хариуцан ажиллахаар зохицуулсан. Энэхүү ажлын хүрээнд тус яам Санхүүгийн мэдээллийн технологийн төв Улсын төсөвт үйлдвэрийн газартай “Хамтран ажиллах гэрээ” болон “Системийн хөгжүүлэлт, тасралтгүй ажиллагааг хангах гэрээ”-г байгуулахаар ажиллаж байна. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/158 дугаар тушаалаар батлагдсан хуримтлалын сангийн мэдээллийн нэгдсэн сангийн программын бодлогын даалгаврыг боловсруулахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх бодлогын зөвлөхийг сонгон шалгаруулсан. Мөн хуримтлалын сангийн мэдээллийн нэгдсэн системийн программын бодлогын даалгаврыг боловсруулахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх бодлогын зөвлөхийн ажлын даалгаврыг боловсруулж, батлуулсан.</p>	90
			Боловсруулсан ажлын даалгаврын тоо	-	1		
			Шинээр нэвтрүүлсэн цахим үйлчилгээний тоо	-	1		
4.1.3	<p>Арга хэмжээ. 4.1.3 Нийгмийн даатгалын хууль тогтоомжтой холбоотой иргэд, даатгуулагчид, ажил олгогчдоос ирүүлж байгаа өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд</p>	-	Нийт ирүүлсэн өргөдөл, гомдолд хуулийн хугацаанд шийдвэрлээгүй өргөдөл, гомдлын эзлэх хувь	0	10 ≤	<p>Эхний хагас жилийн байдлаар нийт 1016 өргөдөл, гомдол ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан. Нийт өргөдлийн 14 хувь нь тэтгэвэр тогтоолт, итгэлцүүртэй холбоотой байгаа бол 79 хувь нь тэтгэвэр барьцаалсан зээлтэй холбоотой, 6 хувь нь тэтгэмжийн даатгалтай</p>	100

	<p>шийдвэрлэж, өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийнэ.</p>		<p>Дүн шинжилгээний тайлан</p>	<p>0</p>	<p>1</p>	<p>холбоотой байна. Тайлант хугацаанд хуулийн хугацаа хэтэрсэн өргөдөл гомдол (нийгмийн даатгалын холбогдох газар, нэгжээс тодруулах, холбоо барих утсаа аваагүй зэрэг) 7 буюу нийт өргөдөл гомдлын 0.7 хувийг эзэлж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Иргэдээс ирүүлж байгаа дээрх өргөдөл, гомдол, саналд дүн шинжилгээ хийхэд нийт өргөдөл, гомдол, саналын 80 орчим хувь нь Монголбанкны мөнгөний бодлогын шийдвэрийн дагуу Монголбанкны ерөнхийлөгчийн 2025.03.07-ны өдрийн А-57 дугаар тушаалаар тэтгэвэр барьцаалсан зээлийг амьжиргааны доод түвшинтэй уялдуулан олгох хязгаарлалт тогтоосонтой холбоотой байна. • Тэтгэврийн зээлд тавьсан хязгаарлалттай холбоотойгоор нийгэмд өрнөж буй шүүмжлэл, иргэдийн санал гомдлыг шийдвэрлэх зорилгоор Монголбанкны холбогдох газартай хамтран ажиллаж, тэтгэврийн зээл авч байгаа байдал, ирүүлсэн өргөдөл, гомдол, саналын агуулга, тэтгэврийн хэмжээ, арилжааны банкуудад авсан зээлийн мэдээлэл болон олон улсын байгууллага, ерхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны дата мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийсэн. Энэ хүрээнд тэтгэврийн зээлийг зохицуулалтыг нэг талаас тэтгэврийн зээлтэй иргэдийн өрийн дарамтыг бууруулж, эдийн засаг, нийгмийн баталгааг хангах, нөгөө талаас банкны салбарын 	
--	--	--	--------------------------------	----------	----------	--	--

						хэрэглээний зээлийн хэт өсөлтийг хязгаарлах зорилгод тулгуурлан зээлийн шалгуур, нөхцөлийг өөрчлөх бодлогын 4 хувилбаруудыг гаргаж, шийдвэр гаргагч нарт танилцуулан хэлэлцүүлсэн. Ингэснээр Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлийн 2025.06.13-ны өдрийн хурлаар тэтгэврийн зээлийн шалгуурыг зөөлрүүлж, хэрэглээний зээлийн шалгуур нөхцөлтэй адил буюу өр, орлогын харьцааг 50 хувиар 30 сар хүртэл хугацаагаар олгохоор шийдвэрлэсэн болно.	
Нийт арга хэмжээний биелэлт 90%							

Төлөвлөгөөг үнэлсэн:

Төрийн нарийн
бичгийн дарга
(албан тушаал)
Тэмдэг

Төсвийн шууд захирагч


 /Л.Мөнхзул/
(гарын үсэг)

(огноо)

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын дарга
(албан тушаал)

Нэгжийн дарга

 /Д.Ренчиндорж/
(гарын үсэг)

(огноо)

Тайлагнасан:

Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн
бодлогын газрын дарга
(албан тушаал)

Нэгжийн дарга

 /В.Рэнцэнханд/
(гарын үсэг)

**НИЙГМИЙН ДААТГАЛ, ХУРИМТЛАЛЫН САНГИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА
ВАНЧИН ОВОГТОЙ РЭНЦЭНХАНДЫН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
Нэгжийн нэр: Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	90.0	63.0

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Арга хэмжээ 1. "Монгол Улсын Төлөөллийн Тогтолцоо - PROST зөвлөхөөр төлөөлөл" Дэлхийн Банкны хэлтэсний зурвас - семинар	100%	15 15
2.	Арга хэмжээ 2. (2025.04.28)		
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			15 15

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	15
2.	Удирдан зохион байгуулах	15
3.	Асуудал шийдвэрлэх	15
4.	Манлайлах	15
5.	Багаар ажиллах	15
6.	Харилцаа	15
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		

7.	Мэргэжлийн ур чадвар 1.	15
8.	Мэргэжлийн ур чадвар 2.	15
9.	Мэргэжлийн ур чадвар 3.	15
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		15

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)	70 хүртэлх оноо 63.0
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15 хүртэлх оноо 15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15 хүртэлх оноо 15
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		93

Үнэлгээ өгсөн:

Төрийн нарийн бичгийн дарга
(албан тушаал)

Үнэлгээтэй танилцсан:

Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга
(албан тушаал)



Төсвийн шууд захирагч

(гарын үсэг)

Нэгжийн дарга

/Л.Мөнхзул/

(огноо)

/В.Рэнцэнханд/

(гарын үсэг)

(огноо)